

**Статистикийн хэлтсийн 4 дүгээр сарын 27-ноос 5 дугаар сарын 03-ны өдрийг  
хүртлэх 7 хоногт хийсэн  
ажлын товч мэдээ**

**2018.05.03**

**Өлгий**

1. Судлаач нарын цуглуулсан ажиллах хүчний судалгааны материалыг хянаж, графикт хугацаанд нь онлайнгаар ҮСХ-нд хүргүүлэв.
2. Хэлтсийн портал сайтанд тухай бүр шаардлагатай мэдээллийг байршуулав.
3. Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2017 оны инфографик мэдээллийг хэвлэн тархааж ажиллаж байна.
4. Жилийн эцсийн мэдээ болох худалдаа, аж үйлдвэрлэл, барилга, зочид буудал, зоогийн газрын мэдээнүүдийн ҮСХ-ноос ирүүлсэн тодруулгыг хугацаандаа тодруулан хүргүүлэв.
5. 2018 оны Гэнэтийн ослын даатгал шинэчлэгдэх гэж байгаатай холбогдуулан хэлтсийн дарга, судлаач, жолооч нарын судалгааг шинэчилж хугацаанд нь зохих газарт хүргүүлсэн
4. Төсвийн гүйцэтгэлийн зарлагын 4 дүгээр сарын мэдээг хугацаанд нь Үндэсний статистикийн хороонд хүргүүлэв.
5. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Гадаад харилцааны яамны харьяа Техник, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Энэтхэг улсын Колката хотноо 2018 оны 08-р сарын 1-нээс 2019 оны 5-р сарын 31-ний өдрүүдэд / 10 сар/ Олон Улсын статистикийн боловсролын төвөөс зохион байгуулагдах Статистикийн 72 дахь сургалтад суралцах тухай мөн Бүгд Найрамдах Казакстан Улсын Алмата хотод "Төрийн бодлого" сэдвээр магистрийн зэргэг хамгаалах 1 жилийн тэтгэлэгт хөтөлбөрт хамаарагдах талаарх ҮСХ-оос ирүүлсэн албан бичгийн хариуг зохих газарт явуулав.
6. Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу 2018 онд албан хаагч нэг бүртэй байгуулсан үр дүнгийн гэрээнд Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тухайн нэгжид хамааралтай ажил үйлчилгээ, нэгдсэн чуулганаас гарсан уриалга, тухайн онд хэрэгжүүлэх томоохон шинэлэг ажил зэргийг тусгаж ҮСХ-ны Захиргаа, хүний нөөцийн хэлтэст хүргүүлэв.

7. Хөдөө аж ахуйн салбарын 2017 оны танилцуулга болон Хүн ам, өрхийн төлөв байдал 2017 оны зайлшгүй хийх танилцуулгын хүснэгт, графикийг хийж, үр дүнгийн тойм танилцуулгыг бэлтгэж, хэлтсийн вэб сайтад байршуулав.
8. ХАӨМСанд Өлгий сумын 3-р багийн дотоод шилжих хөдөлгөөнүүдийг хийж, баталгаажуулан алдаатай мэдээллүүдийг засаж залруулга хийсэн.
9. Аж ахуйн нэгж, байгууллагад шаардлагатай статистикийн тоон мэдээлэл бэлтгэж өгсөн

#### **Статистикийн хэлтэс**